

МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН ЗАХИАЛГААР ХИЙГДСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

Монгол Улсын Их Хурал 2000 оны 04 дүгээр сард “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хууль нэртэйгээр анхлан баталсан. 2005 оны 12 сард одоогийн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль гэсэн шинэчилсэн нэртэй болгон 2007-оос 2016 онуудад хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Уг хууль гарснаар Монгол Улсын Засгийн газар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг илүү үр дүнтэй, ил тод, мэргэжлийн түвшинд явуулахад анхаарч эрх зүйн орчныг боловсронгуй болгох Худалдан авах ажиллагааны зохистой бүтэц тогтолцоог бий болгох, чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Стратегийн зорилтуудын хүрээнд Худалдан авах ажиллагааг улс орны эдийн засгийн үр ашиг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, ард нийтийн амьдралын тохь тухтай, аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэх зорилгоор нийтийн хэрэгцээнд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг төр, орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шударга авлигаас ангид, хэмнэлттэй, үр өгөөжтэй мэргэжлийн байгууллагаар зохион байгуулж цахим тендер шалгаруулалт болон олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, олон нийтийн үндэслэлгүй хардлагаас хамгаалах, нийгмийн шударга ёсны тогтолцоог бэхжүүлж олон нийтийн итгэл нэмэгдэнэ.

Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,-д заасан худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална:

1. Ил тод байх зарчим
2. Өрсөлдөх тэгш боломжтой байх зарчим
3. Үр ашигтай, хэмнэлттэй байх зарчим
4. Хариуцлагатай байх зарчим

Засгийн газар худалдан авах ажиллагаанд оролцох эрх үүрэг:

Монгол улсын иргэний хууль 25 дугаар зүйлийн 1 дэх аливаа гэрээ ямар ч тохиолдолд хуулийн хоёр этгээдийн, эсвэл иргэний хооронд хийгддэг. Энэ үед тухайн яамны сайд болон дээд албан тушаалтан засгийн газрыг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах боловч худалдан авах үйл явц, гэрээний хэрэгжилтийг яам дангаараа хариуцан гүйцэтгэдэг байна. Нутгийн удирдлагын байгууллагууд нь бие даасан санхүүгийн эрх, үүрэг бүхий тусдаа хуулийн этгээд байдаг. Иймээс худалдан авах ажиллагаанд тэд засгийн газрын өмнөөс биш, өөрсдөө бие даан гэрээ хийх чадамжтай байгууллага байна. Нутгийн

удирдлагын байгууллага нь үйл ажиллагааг бүрэн хариуцах ба шаардлагатай тохиолдолд шүүхэд хариуцагчаар татагдах боломжтой. Худалдан авах ажиллагааг хариуцаж буй ажилтан (алба, газар) худалдан авалтын хүчин төгөлдөр хууль, тогтоомж, журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг ёс зүйтэй, шударга, хариуцлагатай, өрсөлдөөнийг тэгш хангаж зохион байгуулах учиртай. Төрийн албан хаагчид тухайн худалдан авах ажиллагаанд оролцохдоо ашиг сонирхлын зөрчилтэй бол мэдэгдэх үүрэгтэй.

Хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд худалдан авах ажиллагаанд оролцох эрх үүрэг:

Төр хувийн хэвшлийн түншлэл нь нийгэмд шууд үр ашгаа өгөх бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх, үйлдвэрлэх, нийлүүлэхэд хувийн хэвшлийг оролцуулна гэсэн үг юм. Хувийн хэвшлийнхэн шаардлагатай стандарт хангасан ажил, үйлчилгээ үзүүлж чадахгүй байна гэж үзж байгаа бол үр бүтээлтэй, ил тод нээлттэй, өрсөлдөөнийг дэмжсэн санаачилга зөвлөгөөг төрд өгч, хамтран ажиллаж болно. Хувийн хэвшил төрийн худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгчээр оролцохдоо гэрээний шаардлага бүрийг биелүүлж, захиалсан бараа, үйлчилгээг яг цагт нь нийлүүлж байх үүрэгтэй. Түүнчлэн хувийн хэвшлийн төлөөлөл худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд саналын эрхтэй оролцох эрхтэй бөгөөд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээтэй байх шаардлага тавигддаг.